



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 6/164

Хэрлэн сум

**Ж.Сарантуяаг ажлаас чөлөөлж,
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 42 дугаар зүйлийн 42.1.1, 43 дугаар зүйлийн 43.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 79 дүгээр зүйлийн 79.1, дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 тогтоолын 10 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", аймгийн Засаг даргын 2023 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" Б/47 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан Жамбалсүрэнгийн Сарантуяаг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс аж ахуйн тасгийн үйлчлэгчээс чөлөөлж, Тогооч, үйлчилгээ хариуцсан ахлах ажилтнаар томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын

дарга: Н.Баярсайхан

Аж ахуйн тасгийн дарга

Гишүүд: Э.Ариунтунгалаг

Нягтлан бодогч

Т.Баяртуяа

Нярав

3. Ж.Сарантуяагийн сарын үндсэн цалинг ТҮ-2 зэрэглэлээр тогтоон, 788,000 (долоон зуун наян найман мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Ж.Сарантуяагийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Н.Баярсайхан)-т, холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА